ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ ХИЙЛГЭХЭЭР ХОЛБОГДОХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ХАНДАЖ БУЙ ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ДОР ДУРДСАН БИЧИГ БАРИМТЫГ БҮРДҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ.

Үүнд:

1. Төсөл хэрэгжүүлэгчийн ерөнхий үнэлгээ хийлгэх тухай хүсэлт/иргэний үнэмлэхийн хуулбар, өргөдөл/,
2. Холбогдох эрх бүхий байгууллагаар баталгаажсан техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл,
3. Тухайн төсөл нь хэрэгжих орон нутгийн хөгжлийн хөтөлбөртэй хэрхэн уялдах боломжтой талаарх тухайн сумын Засаг даргын санал,
4. Төсөл хэрэгжүүлэгчийн аж ахуй нэгж, байгууллагын гэрчилгээ, газар ашиглах, эзэмших, ашигт малтмал хайх, ашиглах талаарх эрх бүхий байгууллагын шийдвэр, эсвэл тусгай зөвшөөрөл, түүний эрхийг шилжүүлсэн тухай баримтын хуулбар,
5. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан байдлын тодорхойлолт,
6. Төсөл хэрэгжих орчны тойм зураг,
7. Аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар,
8. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт.